



2019 оны 04 дүгээр сарын 26
№17/1070/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Төрийн болон орон нутгийн
өмчийн хөрөнгөөр бараа,
ажил, үйлчилгээ худалдан
авах тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Албан тушаалд томилох
тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Мэргэжлийн боловсрол,
сургалтын талаар авах зарим
арга хэмжээний тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

127.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		557
------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	-----

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

128.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 61	564
129.	Албан тушаалд томилох тухай	Дугаар 66	564
130.	Албан тушаалд томилох тухай	Дугаар 67	564

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

131.	Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 12	565
132.	Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 24	569
133.	Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 25	581

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 03 дугаар
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.10 дахь хэсэг:

“3.10.Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дотоодын болон олон улсын санхүүгийн зах зээл дээр



үнэт цаас гаргах, арилжаалах, олон улсын зах зээл, банк, санхүүгийн байгууллагаас арилжааны нөхцөлтэй зээл авахтай холбоотой үйлчилгээ худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.”

2/5 дугаар зүйлийн 5.1.24-5.1.29 дэх заалт:

“5.1.24.“өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээ” гэж зөвхөн тухайн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардагдах бараа, ажил, үйлчилгээг;

5.1.25.“худалдан авах ажиллагааны цахим систем” гэж цахим программ хангамжийг ашиглан худалдан авах ажиллагааг төлөвлөх зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих цогц үйл ажиллагаа, мэдээллийн тогтолцоог;

5.1.26.“цахим худалдан авах ажиллагаа” гэж худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглан зохион байгуулах худалдан авах ажиллагааг;

5.1.27.“цахим дэлгүүр” гэж ерөнхий гэрээний дагуу бараа, үйлчилгээг худалдан авахад зориулсан худалдан авах ажиллагааны цахим системийн бүрэлдэхүүн хэсгийг;

5.1.28.“ногоон худалдан авах ажиллагаа” гэж эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг;

5.1.29.“урьдчилсан худалдан авах ажиллагаа” гэж Улсын Их Хурал улсын төсөв батлах, гадаад улс, олон улсын байгууллагатай байгуулах зээл, тусламжийн олон улсын гэрээг соёрхон батлахаас өмнөх шатанд улсын төсөв, зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг урьдчилан зохион байгуулахыг.”

3/7 дугаар зүйлийн 7.4-7.6 дахь хэсэг:

“7.4.Захиалагч гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар сонгон шалгаруулж болно.

7.5.Энэ хуулийн 7.4-т заасан урьдчилсан худалдан авах ажиллагааны журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

7.6.Урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулах улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээний жагсаалтыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.”

4/8 дугаар зүйлийн 8.7.5 дахь заалт:

“8.7.5.энэ хуулийн 10¹.1-д заасан дотоодын үйлдвэрээс авах боломжтой барааг импортын бараанаас тусад нь багцлах.”

5/8 дугаар зүйлийн 8.13 дахь хэсэг:

“8.13.Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно.”

6/10¹ дүгээр зүйлийн 10¹.4 дэх хэсэг:

“10¹.4.Засгийн газар дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг баталсан тогтоолын хэрэгжилт, үр дүнд жил бүр үнэлгээ, шинжилгээ хийж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр оруулна.”

7/20 дугаар зүйлийн 20.7.3 дахь заалт:

“20.7.3.тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.”

8/29 дүгээр зүйлийн 29.6, 29.7 дахь хэсэг:

“29.6.Урьдчилсан худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтад шалгарсан тендерт оролцогчтой тухайн зээл, тусламжийн олон улсын гэрээ, улсын төсвийн санхүүжилт батлагдаагүй тохиолдолд гэрээ байгуулахыг хориглоно.

29.7.Энэ хуулийн 29.4-т заасан тендерийн хүчинтэй байх хугацаа өнгөрснөөс хойш энэ хуулийн 29.6-д заасан зээл, тусламжийн олон улсын гэрээ, улсын төсвийн санхүүжилт батлагдсан тохиолдолд тухайн тендер шалгаруулалтыг хүчинтэйд тооцно.”

**9/34 дүгээр зүйлийн 34.1.10 дахь заалт:**

“34.1.10.хүнсний аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагаар чанарын шаардлага хангасан тарианы үрийг үйлдвэрлэгчээс авах бол.”

10/36 дугаар зүйлийн 36.18 дахь хэсэг:

“36.18.Энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан зөвлөх сонгох тендер шалгаруулалт хоёр удаа амжилтгүй болсон тохиолдолд шууд гэрээ байгуулж болно.”

11/52¹ дүгээр зүйлийн 52¹.3 дахь хэсэг:

“52¹.3.Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм болон тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.”

12/55 дугаар зүйлийн 55.9 дэх хэсэг:

“55.9.Тендерт оролцогчдын гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ хуулийн 20.7.3-т заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгох дээд хэмжээ 20 сая төгрөгөөс хэтрэхгүй байна. Гомдлыг үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол тендерийн баталгааг буцаан олгоно.”

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4 дэх хэсгийн “10.1.4,” гэсний дараа “10.1.6,” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “өдөр тутмын сонин,” гэсний дараа “худалдан авах ажиллагааны цахим систем болон” гэж, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “хүлээлгэн өгснөөр” гэсний дараа “, эсхүл худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлснээр” гэж, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсгийн “нээлт хийхээс” гэсний дараа “ажлын 10-аас доошгүй өдрийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйлийн 5.1.23 дахь заалт:

“5.1.23.“ерөнхий гэрээ” гэж захиалагч нь байнгын хэрэгцээтэй бараа, үйлчилгээг нэг ба түүнээс дээш нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчтэй 3 хүртэл жилийн хугацаанд үнэ болон бусад нөхцөлийг тохирч байгуулсан гэрээг.”

2/10¹ дүгээр зүйлийн 10^{1.2} дахь хэсэг:

“10^{1.2}.Энэ хуулийн 10^{1.1}-д заасан дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.”

3/11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2 дахь заалт:

“11.1.1.тухайн бараа, ажил, үйлчилгээг гадаад шинж чанарын үзүүлэлтээр бус, зориулалт, эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээ, ашиглалт, чанарын түвшин, техникийн болон тухайн бараа, ажил, үйлчилгээ нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн шалгуур үзүүлэлтээр тодорхойлох;

11.1.2.үндэсний стандарт, техникийн шаардлага, норм, норматив, дүрэм, зааварт үндэслэх, үндэсний стандарт, техникийн норм байхгүй тохиолдолд Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн олон улсын стандартад үндэслэх;”

4/21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэг:

“21.3.Энэ хуулийн 9.2-т заасан этгээдийн тендерийн урилгыг олон улсын худалдаанд өргөн хэрэглэгддэг хэл дээр гардаг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.”

5/22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг:

“22.2.Захиалагч тендерийн баримт бичгийн үнийг тендер зохион байгуулах үйл ажиллагааны бодит зардлыг үндэслэн тогтоож тендерт оролцохыг сонирхсон этгээдэд уг үнээр саадгүй худалдана.”

6/28 дугаар зүйлийн 28.7.3 дахь заалт:

“28.7.3.энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж, энэ хуульд заасны дагуу үнэлэгдсэн тендерүүдийг бага харьцуулах үнэтэйгээс их харьцуулах үнэтэй рүү нь эрэмбэлж, хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгоно;”

7/33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалт:

“33.2.1.үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх;”



8/45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг:

“45.7.Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, хил хамгаалах байгууллага, цагдаа, дотоодын цэрэг, хорих байгууллагын тусгай хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээг тухайн салбарын төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэх, хорих байгууллагын өөрийн хэрэгцээний ажлыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгүүлэх нь үр ашигтай гэж захиалагч үзсэн, түүнчлэн хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрын худалдан авах ажиллагааг зохион байгуулахад төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авсан зөвшөөрлийн үндсэн дээр нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхгүй байж болно.”

9/46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт:

“46.1.6.гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутам худалдан авах ажиллагааны цахим системд оруулах;”

10/47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсэг:

“47.5.Энэ хуулийн 47.4 дэх хэсэгт заасан үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилох, тэднийг төрийн зардлаар мэргэшүүлж сургах болон ажиллах журмыг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

11/52 дугаар зүйлийн 52.1.3, 52.1.7 дахь заалт:

“52.1.3.худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, аргачлал, жишиг баримт бичгийн төсөл, цахим тендер шалгаруулах журам, тендер шалгаруулалтын материалыг тухайн тендер оролцогчдоод ил болгох журам, цахим худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам, худалдан авах ажиллагаанд мэдээллийн технологи, цахим хэрэгслийг нэвтрүүлэх нөхцөл, журам батлах;

52.1.7.энэ хуульд заасны дагуу тендер оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журмыг батлах;”

12/55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг:

“55.2.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар энэ хуулийн 55.1-д заасан гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоног

багтаан хянан шийдвэрлэнэ. Шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар тендерт оролцогч дахин гомдол гаргасан тохиолдолд хүлээн авахаас татгалзана.”

4 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтын “гэрээ байгуулахыг баталгаажуулж” гэснийг “гэрээ байгуулах, хариуцлагатай оролцохоо баталгаажуулж” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.12 дахь заалт, 53 дугаар зүйлийн 53.5.4 дэх заалтын “вэб” гэснийг “цахим” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “эрх олгож болно.” гэснийг “эрх олгоно.” гэж, 10.2 дахь хэсгийн “10.1.1, 10.1.3-т” гэснийг “10.1.1, 10.1.3, 10.1.6-д” гэж, 10.1.7 дахь заалтын “50” гэснийг “30” гэж, 10¹.1 дэх хэсгийн “шалгаруулахыг” гэснийг “оролцуулахыг” гэж, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “үүссэнийг” гэснийг “үүссэн болохыг” гэж, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн “45” гэснийг “30” гэж, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “5-аас” гэснийг “6-аас” гэж, 29.4 дэх хэсгийн “30” гэснийг “15” гэж, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн “илгээсэн” гэснийг “зарласан” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтын “33.4-т” гэснийг “36.18-д” гэж, 34.1.2 дахь заалтын “эрхийг” гэснийг “эрх, соёлын биет өвийг” гэж, 46 дугаар зүйлийн 46.1.5 дахь заалтын “тухайн” гэснийг “энэ хуулийн 7.6-д зааснаас бусад” гэж, 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, 53 дугаар зүйлийн гарчиг, 53.1, 53.5, 53.7 дахь хэсгийн “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж, 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг, 53 дугаар зүйлийн 53.3, 53.4 дэх хэсэг, 53.5.2, 53.5.6 дахь заалт, 53.6 дахь хэсгийн “төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” гэснийг “Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.6, 3.7, 3.8 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.15 дахь заалт, 52.2, 52.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 04 дүгээр
сарын 10-ны өдөр

Дугаар 61

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргасан шүүгч Дорлигийн Лувсандоржийг Багахангай дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн, шүүгч Сэрээтэрдагвын Байгальмааг Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 04 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 66

Улаанбаатар
хот

Албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 2, Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Содонгийн Алиманцэцэгийг Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчоор томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2019 оны 04 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар
хот

Албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 2, Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Максимын Чинбатыг Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогчоор томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 1 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

**Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар
авах зарим арга хэмжээний тухай**

Боловсролын тухай хуулийн 43.2.10, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 17.1.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид хичээлийн жилд сар бүр олгох тэтгэлгийн хэмжээг 100,000 /нэг зуун мянган/ төгрөгөөр тогтоосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2013 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 329 дүгээр тогтоол, “Журам шинэчлэн батлах тухай” 2015 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн 477 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЧИНЗОРИГ

Засгийн газрын 2019 оны 12 дугаар
тогтоолын хавсралт

**МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
СУРАЛЦАГЧИД ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсад мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн болон төрийн бус өмчийн мэргэжлийн



боловсрол сургалтын байгууллага (цаашид “сургалтын байгууллага” гэх)-ын суралцагчид тэтгэлэг олгоход энэ журмыг баримтална.

1.2. Сургалтын байгууллагын мэргэжлийн боловсролын түвшний 2.5 жил, 1 жилийн өдрийн анги, техникийн боловсролын түвшний 3 жил, 1.5 жилийн өдрийн ангид суралцаж байгаа суралцагчид тэтгэлгийг олгоно.

Хоёр. Тэтгэлэг олгох нөхцөл

2.1. Сургалтын байгууллага нь дараахь шаардлагыг хангасан байна:

2.1.1. мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;

2.1.2. мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан элсэлтийн хяналтын тоо, мэргэжлийн чиглэлийн дагуу элсэлт зохион байгуулсан байх;

2.1.3. сургалтын агуулга, хөтөлбөр, төлөвлөгөөг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан байх.

2.2. Суралцагч нь дараахь шаардлагыг хангасан байна:

2.2.1. мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон суралцах эрхийн бичигтэй байх;

2.2.2. мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын нэгдсэн цахим системд бүртгэгдсэн байх;

2.2.3. сургалтын байгууллагын дотоод журам, суралцагчийн ёс зүйн дүрмийг зөрчөөгүй, хичээлийн хуваарийн дагуу тухайн сарын онолын болон дадлагын сургалтад 75-аас дээш хувийн ирцтэй хамрагдсан байх;

2.2.4. хүндэтгэн үзэх шалтгаан (эрүүл мэндийн болон ар гэрийн гачигдал гэх мэт)-ы улмаас сургалтад хамрагдаагүй нь чөлөөний хуудас, эмнэлгийн магадлагаагаар тодорхойлогдсон байх.

Гурав. Санхүүжилт

3.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23.1.2-т заасны дагуу суралцагчид олгох тэтгэлгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлнэ.



3.2. Сургалтын байгууллага нь суралцагчийн тухайн сарын үнэлгээ, ирцийн мэдээллийг энэ журмын хавсралтад заасан маягтын дагуу мэргэжлийн боловсрол, сургалтын нэгдсэн цахим системд бүртгэх буюу дараа сарын 5-ны өдрийн дотор Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд цаасан хэлбэрээр баталгаажуулан хүргүүлнэ.

3.3. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь энэ журмын 3.2-т заасан мэдээллийг хянан баталгаажуулж, суралцагчийн банкин дахь харилцах дансанд сар бүрийн 15-ны өдрийн дотор тэтгэлгийг шилжүүлнэ.

3.4. Суралцагч сургалтын байгууллагаас албан ёсны чөлөө авсан, сургуулиа орхисон тохиолдолд тэтгэлгийг зогсооно. Энэ тохиолдолд сургалтын байгууллагын эрх бүхий албан тушаалтан албан ёсны шийдвэр гаргасан байна.

3.5. Тэтгэлгийг нэг хичээлийн жилд 10 хүртэл сарын хугацаанд олгоно.

Дөрөв. Хяналт баталгаажуулалт

4.1. Сургалтын байгууллага суралцагчийн ирцийн мэдээллийг бодитой бус үнэлсэн, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, тэтгэлэгтэй холбоотой мэдээллийг буруу гаргасан, удаа дараа хугацаа хоцроож ирүүлсэн бол сургалтын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэж буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлнэ.

4.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тэтгэлэг олголтын явцад хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, зохих дүгнэлт гаргана.

Тав. Бусад

5.1. Сургалтын байгууллага нь дараахь баримт бичгийг дор дурдсан хугацаанд Мэргэжлийн боловсрол, сургалтын дэмжих санд хүргүүлнэ:

5.1.1. сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбарыг хүчинтэй байх хавсралт хуудсын хамт хичээлийн шинэ жилийн эхэнд;

5.1.2. суралцагчдыг шинээр элсүүлсэн, төгсгөсөн болон анги дэвшүүлсэн, чөлөөлсөн, хасагдсан зэрэг шилжилт хөдөлгөөний тухай захирлын тушаалын хуулбарыг тухай бүр.



“Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдад тэтгэлэг олгох журам”-ын хавсралт

..... (байгууллагын нэр) СУРАЛЦАГЧДЫН 2019 ОНЫ ...-Р САРЫН ТЭТГЭЛГИЙН ТООЦОО

... он... сар... өдөр

№	Овог	Нэр	Регистрийн дугаар	Банкны нэр	Дансны дугаар	Анги	Түвшин	20 ... оны ...-р сарын хичээлийн ирц	Ирцийн хувь	Нийт олгохоор тооцсон тэтгэлгийн мөнгөн дүн
1.										
2.										
3.										
4.										
5.										
6.										
7.										
8.										
...										

Нийт дүн

Танилцсан: Сургуулийн захирал: / Нэр
(Гарын үсэг)

Хянасан: Сургалтын менежер: Нэр
(Гарын үсэг)

Тооцооллыг хийж гүйцэтгэсэн: Нэр
(Гарын үсэг)

Нягтлан бодогч: Нэр
(Гарын үсэг)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 24

Улаанбаатар
хот

Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 57.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилтгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр хавсралт, Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар хавсралт, Төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар хавсралт, Шинжлэх ухааны байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээг 4 дүгээр хавсралт, Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээг 5 дугаар хавсралт, Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээг 6 дугаар хавсралт, Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээг 7 дугаар хавсралт, Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээг 8 дугаар хавсралт, Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээг 9 дүгээр хавсралт, Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээг 10 дугаар хавсралт, Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг 11 дүгээр хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталж, 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтооход шаардагдах хөрөнгийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.



3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 79 дүгээр тогтоолд заасан нийслэл, аймаг, дүүрэг, сумын Засаг даргын орлогч нарын албан тушаалын цалингийн жишиг болон “Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2014 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 333 дугаар тогтоол, “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн 264 дүгээр тогтоолыг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЧИНЗОРИГ

Засгийн газрын 2019 оны 24 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧ, ЗАСГИЙН ГАЗАР, ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ, УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС, ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ, ҮНДЭСНИЙ АЮУЛГУЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ, СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО БОЛОН ТЭДГЭЭРТЭЙ АДИЛТГАХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН АЛБАНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл										
	AA-11	AA-10	AA-9	AA-8	AA-7	AA-6	AA-5	AA-4	AA-3	AA-2	AA-1
1	569465	594803	638906	689597	745358	806694	874164	911273	951239	992197	1009404
2	602635	629895	677340	731876	791864	857852	930438	970360	1012684	1056715	1075209
3	635813	664994	715783	774163	838381	909020	986722	1029459	1074333	1121448	1141237
4	667910	698951	752976	815075	883383	958522	1015663	1047650			
5	700002	732900	790162	855978	928378	1008016	1044602	1065841			



Засгийн газрын 2019 оны 24 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл													
	ТЗ-1	ТЗ-2	ТЗ-3	ТЗ-4	ТЗ-5	ТЗ-6	ТЗ-7	ТЗ-8	ТЗ-9	ТЗ-10	ТЗ-11	ТЗ-12	ТЗ-13	ТЗ-14
1	477434	507442	542123	569465	594803	638906	689597	745358	806694	874164	911273	951239	992197	1009404
2	503627	535910	573221	602635	629895	677340	731876	791864	857852	930438	970360	1012684	1056715	1075209
3	529825	564384	604324	635813	664994	715783	774163	838381	909020	986722	1029459	1074333	1121448	1141237
4	555170	591930	634415	667910	698951	752976	815075	883383	958522	1015663	1047650			
5	580511	619472	664502	700002	732900	790162	856978	928378	1008016	1044602	1065841			

Засгийн газрын 2019 оны 24 дүгээр
тогтоолын 3 дугаар хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл																		
	ТТ-1	ТТ-2	ТТ-3	ТТ-4	ТТ-5	ТТ-6	ТТ-7	ТТ-8	ТТ-9	ТТ-10	ТТ-11	ТТ-12	ТТ-13	ТТ-14	ТТ-15	ТТ-16	ТТ-17	ТТ-18	
1	430389	460229	476251	502546	512328	530967	550915	571862	593855	616948	641197	666657	693389	721460	750932	843773	879361	894306	
2	456604	489065	506495	535099	545742	566016	587718	610505	634431	659552	685931	713628	742710	773246	805307	906303	945018	961276	
3	481990	516988	535782	566623	578097	599958	623357	647925	673722	700808	729249	759113	790469	823392	857962	966856	1008598	1026128	
4	505658	543024	563088	596015	608265	631605	656586	682815	710357	739276	769639	801522	834998	870148	907056				
5	530042	569847	591219	626296	639346	664208	690819	718760	748099	778904	811251	845212	880874	918318	957633				

Засгийн газрын 2019 оны 24 дүгээр
тогтоолын 4 дүгээр хавсралт

ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл						
	ТҮШУ-1	ТҮШУ-2	ТҮШУ-3	ТҮШУ-4	ТҮШУ-5	ТҮШУ-6	ТҮШУ-7
1	604521	757765	819775	874685	933647	997326	1066098
2	609231	764023	826658	882056	941606	1005920	1075379
3	621201	779923	844148	900666	961706	1027629	1098826
4	651568	820255	868581				
5	685444	865251	893016				

Засгийн газрын 2019 оны 24 дүгээр
тогтоолын 5 дугаар хавсралт

СҮРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА, ДҮНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХ СҮРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл				
	ТҮБД-1	ТҮБД-2	ТҮБД-3	ТҮБД-4	ТҮБД-5
1	543875	651503	694193	758113	820151
2	547974	656689	699637	764373	827037
3	558387	669861	713468	780280	844534
4	584805	703279	748557	820631	868980
5	614276	740561	787701	865647	893425

Засгийн газрын 2019 оны 24 дүгээр
тогтоолын 6 дугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГУУЛИЙН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СУЛЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Цалингийн сулжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл								
	ТҮМБ-1	ТҮМБ-2	ТҮМБ-3	ТҮМБ-4	ТҮМБ-5	ТҮМБ-6	ТҮМБ-7		
1	579598	624358	648977	726525	785977	838624	895155		
2	584114	629328	654193	732525	792577	845691	902787		
3	595591	641950	667449	747769	809346	863534	922058		
4	624705	673976	701075	786438	832772				
5	657185	709704	738589	829579	856199				

Засгийн газрын 2019 оны 24 дүгээр
тогтоолын 7 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл								
	ТҮЭМ-1	ТҮЭМ-2	ТҮЭМ-3	ТҮЭМ-4	ТҮЭМ-5	ТҮЭМ-6	ТҮЭМ-7	ТҮЭМ-8	ТҮЭМ-9
1	506952	543875	604797	651503	677193	758113	820151	875086	934075
2	510679	547974	609510	656689	682637	764373	827037	882461	942038
3	520144	558387	621486	669861	696468	780280	844534	901079	962147
4	544161	584805	651866	703279	731557	820631	868980		
5	570953	614276	685758	740561	770701	865647	893425		

Засгийн газрын 2019 оны 24 дүгээр
тогтоолын 8 дугаар хавсралт

СОЁЛ, УРЛАГИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл						
	ТҮСУ-1	ТҮСУ-2	ТҮСУ-3	ТҮСУ-4	ТҮСУ-5	ТҮСУ-6	ТҮСУ-7
1	485830	521214	579598	624358	726525	838624	895155
2	489400	525141	584114	629328	732525	845691	902787
3	498473	535121	595591	641950	747769	863534	922058
4	521487	560438	624705	673976	786438		
5	547164	588681	657185	709704	829579		

Засгийн газрын 2019 оны 24 дүгээр
тогтоолын 9 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРААС БУСАД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН
ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ТУСЛАХ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл											
	ТҮ-1	ТҮ-2	ТҮ-3	ТҮ-4	ТҮ-5	ТҮ-6	ТҮ-7	ТҮ-8	ТҮ-9	ТҮ-10	ТҮ-11	ТҮ-12
1	432754	452933	468980	485830	521214	579598	624357	648977	726525	785978	838624	895155
2	435757	456172	472381	489401	525141	584114	629327	664193	732525	792577	845691	902786
3	443279	464400	481021	498472	535121	595591	641951	667449	747768	809346	863534	922058
4	462826	485276	502940	521487	560438	624705	673976	701075	786438	832773		
5	484635	508565	527393	547164	588681	657185	709704	738589	829579	856199		



Засгийн газрын 2019 оны 24 дүгээр
тогтоолын 10 дугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН
ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ТУСЛАХ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл											
	ТҮ-1	ТҮ-2	ТҮ-3	ТҮ-4	ТҮ-5	ТҮ-6	ТҮ-7	ТҮ-8	ТҮ-9	ТҮ-10	ТҮ-11	ТҮ-12
1	451569	472625	489370	506952	543875	604797	651503	677193	758113	820151	875086	934075
2	454702	476006	492919	510679	547974	609510	656689	682637	764373	827037	882461	942038
3	462552	484591	501935	520144	558387	621486	669861	696468	780280	844534	901079	962147
4	482948	506375	524808	544161	584805	651866	703279	731557	820631	868980		
5	505706	530676	550324	570953	614276	685758	740561	770701	865647	893425		

Засгийн газрын 2019 оны 24 дүгээр
тогтоолын 11 дүгээр хавсралт

УЛС ТӨРИЙН АЛБАН ТУШААЛ ЭРХЭЛДЭГ ЗАРИМ АЛБАН
ХААГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(сард, төгрөгөөр)

Албан тушаал	Албан тушаалын цалингийн хэмжээ
Нийслэлийн Засаг даргын орлогч	939452 – 1036548
Аймгийн Засаг даргын орлогч	905993 – 973210
Дүүргийн Засаг дарга	893192 – 1029603
Дүүргийн Засаг даргын орлогч	712193 – 880000
Сумын Засаг дарга	840108 – 974266
Сумын Засаг даргын орлогч	656110 – 824086
Хорооны Засаг дарга	623130 – 715183
Багийн Засаг дарга	558362 – 645730

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 1 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 25

Улаанбаатар
хот

**Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын
зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 20.1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”-ийг 1 дүгээр хавсралт, “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”-ийг 2 дугаар хавсралт, “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”-ийг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталж, 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 354 дүгээр тогтоолын 3, 4, 5 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

САНГИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

С.ЧИНЗОРИГ

Засгийн газрын 2019 оны 25 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ

№	Зэрэглэл	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаал			“Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08”-д заасан индекс/код	Дүйцүүлэх албан тушаал
		Удирдах	Гүйцэтгэх	Туслах		
1		2	3	4	5	
1.	ТҮЭМ-9	1. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн дарга/захирал 2. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга 3. Улсын хэмжээний рашаан сувиллын дарга				

	<p>1. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн орлогч дарга, дэд захирал</p> <p>2. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн орлогч дарга</p> <p>3. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвийн дарга</p>				<p>1. Төрөлжсөн халамж, асрамж, сэргээн засахын эмнэлгийн дарга</p>
<p>2. ТҮЭМ-8</p>	<p>1. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвийн орлогч дарга</p> <p>2. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвтэй адилтгах байгууллагын дарга</p>	<p>1. Хүний их эмч:</p> <p>1.1. Эрчимт эмчилгээ судлалын</p> <p>1.2. Мэс засал судлалын</p> <p>1.3. Яаралтай тусламж судлалын</p> <p>1.4. Эх барих эмэгтэйчүүд судлалын</p> <p>1.5. Гэмтэл согог судлалын</p> <p>1.6. Мэдээгүйжүүлэг судлалын</p> <p>1.7. Хүүхэд судлалын</p> <p>1.8. Хавдар судлалын</p>		<p>2212-101, 2212-102, 2212-47 – 2212-58, 2212-108 – 2212-110, 2212-103 – 2212-107, 2212-09 – 2212-16, 2212-45, 2212-46, 2212-80 – 2212-91, 2212-73 – 2212-75</p>	<p>2. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвийн зөвлөх эмч</p> <p>3. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн зөвлөх эмч</p> <p>4. Төрөлжсөн халамж, асрамж, сэргээн засахын эмнэлгийн орлогч дарга</p>
<p>3. ТҮЭМ-7</p>					



4. ТҮЭМ-6	<p>1. Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн дарга</p> <p>2. Эмнэлгийн албаны дарга буюу эмнэлгийн чанарын болон хүний нөөцийн менежер</p> <p>3. Аймгийн зэрэглэлтэй хотын нэгдсэн эмнэлгийн орлогч дарга</p>	<p>1. Хүний их эмч:</p> <p>1.1. Сэтгэц судлалын</p> <p>1.2. Чих хамар хоолой судлалын</p> <p>1.3. Мэдрэл судлалын</p> <p>1.4. Нүд судлалын</p> <p>1.5. Дотрын анагаах ухаан судлалын</p> <p>1.6. Халдварт өвчин судлалын</p> <p>1.7. Анатомиийн эмгэг судлалын</p> <p>1.8. Дүрс оношилгооны</p> <p>1.9. Эмнэлзүйн эмгэг судлалын</p> <p>1.10. Сэргээн засал судлалын</p> <p>1.11. Арьс судлалын</p> <p>1.12. Нүүр ам судлалын</p> <p>1.13. Уламжлалт анагаах ухаан судлалын</p> <p>1.14. Ерөнхий мэргэшил судлалын</p>	<p>2212-67 – 2212-72, 2212-92, 2212-93, 2212-41 – 2212-44 2212-59, 2212-60, 2212-17 – 2212-31, 2212-40, 2212-61, 2212-76 – 2212-79, 2212-02 – 2212-05, 2212-32 – 2212-39, 2212-94 – 2212-100, 2212-62 – 2212-66, 2212-06 – 2212-08 2261-01 – 2261-09, 2230-01 – 2230-05, 2211-01</p>	
-----------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--

		<p>1. Хүний их эмч:</p> <p>1.1. Ерөнхий мэргэжлийн эрүүл мэндийн удирдлагын мэдээлэл, эрүүл мэндийн даатгалын 1.3. Эмнэлгийн мэргэжилтний сургалтын</p> <p>2. Эм зүйч</p> <p>3. Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн</p> <p>4. Биоанагаахын мэргэжилтэн</p> <p>5. Эх баригч</p>		<p>2212-113 – 2212-115, 2262-01–2262-08, 3259-01, 2269-01 – 2269-19, 2222-01</p>	<p>1. Өрхийн анагаах судлалын хүний их эмч</p> <p>2. Төрөлжсөн халамж, асрамж, сэргээн засахын эмч</p>
<p>5. ТҮЭМ-5</p>		<p>1. Резидент эмч</p> <p>2. Хоол зүйч</p> <p>3. Бага эмч</p> <p>4. Эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжийн техникч</p> <p>5. Эмчилгээ, эмгэг судлалын лабораторийн техникч</p> <p>6. Эм найруулагч</p> <p>7. Сэргээн засахын мэргэжилтэн</p>		<p>2212-111, 2265-01, 2212-116, 2212-117, 3211-01-3211-09, 3212-01-3212-08, 3213-01, 2264-01-2264-10, 2221-20-2221-22, 2221-07, 2221-08, 2221-11, 2221-01, 2221-14-2221-18, 2221-04, 3214-01</p>	<p>1. Төрөлжсөн халамж, асрамж, сэргээн засахын сувилагч</p>
<p>6. ТҮЭМ-4</p>					



	<p>8. Эмчилгээ, хиймэл шүдний техникч 9. Сувилагч: 9.1. Эрчимт эмчилгээний сувилахуйн 9.2. Яаралтай тусламжийн сувилахуйн 9.3. Мэс заслын сувилахуйн 9.4. Мэдээгүйжүүлгийн сувилахуйн 9.5. Эх, уртийн сувилахуйн 9.6. Нярайн сувилахуйн 9.7. Арга зүйч/Ахлах сувилагч 9.8. Сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн 9.9. Хөнгөвчлөх эмчилгээний сувилахуйн 9.10. Хүүхдийн сувилахуйн 9.11. Гэмтэл согогийн сувилахуйн 9.12. Цус, хавдрын сувилахуйн 9.13. Халдварт өвчний сувилахуйн</p>		
--	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--

	<p>1. Сонгол засалч, хэлний согог засалч 2. Протезийн ажилтан 3. Харааны шилний мэргэжилтэн 4. Эмчилгээний тэмдэглэл, эрүүл мэндийн мэдээллийн техникч 5. Сувилагч: 5.1. Мэдрэлийн сувилахуйн 5.2. Нүдний сувилахуйн 5.3. Нуур амны сувилахуйн 5.4. Чих, хамар, хоолойн сувилахуйн 5.5. Ерөнхий мэргэжлийн сувилахуйн 5.6. Сэргээн засахын сувилахуйн 5.7. Дархлаажуулалтын сувилахуйн 5.8. Арьсны сувилахуйн 5.9. Уламжлалт анагаах ухааны сувилахуйн 5.10. Монголын уламжлалт анагаах ухааны бариа заслын сувилахуйн</p>	<p>1. Эмгэг судлалын туслах ажилтан</p>	<p>2266-01, 2266-02, 3259-07, 3254-01, 3254-02, 3252-01, 3252-02, 2221-06, 2221-09, 2221-10, 2221-19, 2221-02, 2221-03, 2221-13, 2221-05, 3259-04 2221-23 - 2221-26, 3259-02, 2267-01</p>	<p>1. Өрхийн сувилагч 2. Төрөлжсөн халамж, асрамж, сэргээн засахын техникч</p>
<p>7. ТҮЭМ-3</p>				

			5.11. Монголын уламжлалт, анагаах ухааны дотрын сувилахуйн 5.12. Ариутгагч			
8.	ТҮЭМ-2			1. Шүдний эмчийн туслах 2. Туслах сувилагч 3. Түргэн тусламжийн жолооч	8322-16, 3221-01, 3251-01, 3251-02	
9.	ТҮЭМ-1			1. Шил угаагч	3259-06	

Засгийн газрын 2019 оны 25 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БАГА, ДУНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХ СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ

№	Зэрэглэл	Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаал			"Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08"-д заасан индекс/код	Дүйцүүлэх албан тушаал
		Удирдах	Гүйцэтгэх	Туслах		
1		2	3	4	5	
1.	ТҮБД-5	1. Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын захирал 2. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын эрхлэгч			1345-01 – 1345-07, 1341-01 – 1341-03	1. Төрөлжсөн асрамж, халамжийн цэцэрлэгийн эрхлэгч
2.	ТҮБД-4	1. Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын сургалтын менежер	1. Сургуулийн өмнөх боловсрол олгох багш		2351-03 – 2351-07, 2634-12, 2352-35, 2342-01 – 2342-04, 2342-06 – 2342-08	1. Төрөлжсөн асрамж, халамжийн цэцэрлэгийн багш



3.	ТҮБД-3		<p>1. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын арга зүйч</p> <p>2. Нийгмийн ажилтан</p> <p>3. Ерөнхий боловсролын сургуулийн бага боловсрол олгох багш</p> <p>4. Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн багш</p>		<p>2351-01, 2351-02, 2341-01, 2341-02, 2635-22, 2635-35, 2330-01 – 2330-30, 2352-01 – 2352-32</p>	<p>1. Төрөлжсөн асрамж, халамжийн нийгмийн ажилтан</p>
4.	ТҮБД-2		<p>1. Дотуур байрын багш</p>		2359-01, 2352-34	
5.	ТҮБД-1			<p>1. Туулах багш</p>	<p>2342-05, 2352-33, 2359-02</p>	<p>1. Төрөлжсөн асрамж, халамжийн сургууль, цэцэрлэгийн туулах багш</p>

Засгийн газрын 2019 оны 25 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГЛЭЛ

№	Зэрэглэл	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаал			"Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08"-д заасан индекс /код
		Удирдах	Гүйцэтгэх	Туслах	
1.	1	2	3	4	5
1.	ТҮМБ-7	1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захирал			1345-08, 1345-09
2.	ТҮМБ-6	1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дэд захирал 2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын менежер			1345-10, 2351-08

3.	ТҮМБ-5		1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын арга зүйч 2. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын мэргэжлийн багш		2351-09, 2320-19 – 2320-113, 2320-115
4.	ТҮМБ-4		1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын ерөнхий эрдмийн багш		2320-01 – 2320-18
5.	ТҮМБ-3		1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын нийгмийн ажилтан		2635-36
6.	ТҮМБ-2			1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрын багш	2320-114
7.	ТҮМБ-1			1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дадлагажигч багш	

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоог
И-мэйл: turin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.25

Индекс: 200003